МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас/Факс: (976-51) 26 75 33,
Цахим шуудан: info@mojha.gov.mn
Цахим хуудас: www.mojha.gov.mn

2024.11.21 № 1/1893

танай _____-ны №_____-т

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН О.НОМИНЧИМЭГ
ТАНАА

Танаас ирүүлсэн мэдээлэл авах тухай албан бичгийн дагуу холбогдох байгууллагаас ирүүлсэн мэдээллийг хүргүүлж байна.

Хүлээн авч, танилцана уу.

Хавсралт ...4... хуудастай.

О.АЛТАНГЭРЭЛ

15160454

АБ.файл.2024

Хууль зүй, дотоод хэргийн сайдын
2024 оны ..(.сарын 21.өдрийн /А/503 дугаар
албан бичгийн хавсралт

"ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОГЧИД НӨХӨН ТӨЛБӨР ОЛГОХ ЖУРАМ"-ЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТАНИЛЦУУЛГА

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд 2010 онд орсон нэмэлт, өөрчлөлтийг үндэслэн баталсан Засгийн газрын 2011 оны 132 дугаар тогтоолоор "Зарим төрлийн гэмт хэргийн хохирогчид төрөөс нөхөн төлбөр олгох журам"-ын дагуу гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох ажлыг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас 2012 оноос хойш зохион байгуулж байна.

Гэмт хэргийн улмаас хохирсон хохирогч болон түүний хууль ёсны төлөөлөгчид хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийг үндэслэн:

-оршуулгын зардал;

-эмчилгээний зардал;

-хөдөлмөрийн чадвараа алдсанаас дутуу авсан цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын нөхөн төлбөрийг сангаас олгохоор хуульчилж, 2006 оны 6 дугаар сарын 29-ний өдөр батлагдсан Засгийн газрын тусгай сангийн тухай хуулиар хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 20-30 дахин /хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 192.000 төгрөг/ нэмэгдүүлсэн хэмжээгээр нөхөн төлбөр олгохоор заасан байсан. Үүнд:

Эрүүгийн хуулийн Тусгай ангийн зүйл заалт,

1. Хүнийг алах -10.1 /91.1, 91.2/,
2. Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах -11.1 /96.1, 96.2/
3. Хүн барьцаалах -13.3 /112.3/
4. Хүнийг хүчээр алга болгох -13.4
5. Хүчиндэх -12.1 /126.2, 126.3/
6. Дээрэмдэх -17.2 /147.3/
7. Төрийн өндөр албан тушаалтны амь биед халдах -19.3 /81.1, 81.2/
8. Эрүү шүүлт тулгах -21.12 /251.2, 251.3/
9. Түрэмгий дайныг төлөвлөх, бэлтгэх, өдөөх, дэгдээх -29.1
10. Террор үйлдэх -29.8 /178[1].2/

Засгийн газрын тусгай сангийн тухай хууль шинэчлэн батлагдаж, 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж, уг хуульд Эрүүгийн хуулийн Тусгай ангийн 21 зүйл, заалтад заасан гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгохоор хуульчилж, Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 220 дугаар тогтоолоор "Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох журам"-ыг шинэчлэн баталсан.

Дээрх хуулиар төлбөр авагчдад олгох нөхөн төлбөрийг шүүхийн шийдвэрт заасан хэмжээгээр олгохоор хуульчилсан болно.

Нөхөн төлбөр олгох Эрүүгийн хуулийн зүйл, заалт:

1. Хүнийг алах -10.1 /91.1, 91.2/,
2. Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах -11.1 /96.1, 96.2/
3. Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах -11.4
4. Хүн хулгайлах -108.3 /13.2/
5. Хүн барьцаалах -13.3 /112.3/
6. Хүнийг хүчээр алга болгох -13.4
7. Хүн худалдаалах -13.1 /113.3/

8. Хүчиндэх -12.1 /126.2, 126.3/
9. Дээрэмдэх -17.2 /147.3/
10. Төрийн өндөр албан тушаалтны амь биед халдах -19.3 /81.1, 81.2/
11. Эрүү шүүлт тулгах -21.12 /251.2, 251.3/
12. Түрэмгий дайныг төлөвлөх, бэлтгэх, өдөөх, дэгдээх -29.1
13. Террор үйлдэх -29.8 /178[1].2/
14. Бэлгийн мөлжлөг -12.3
15. Хүний цус, эс, эс эрхтнийг хууль бусаар авах -15.3
16. Хууль бусаар үр хөндөх -15.5
17. Хүүхдийг гэмт хэрэг үйлдэхэд татан оруулах -16.1
18. Хүүхдийг хаях, төөрүүлэх, тэнүүчлэлд хүргэх -16.3
19. Хүүхэд худалдах -16.6
20. Хүүхэдтэй хэрцгий харьцах -16.7
21. Хүүхдийг асран хамгаалах үүргээ үл биелүүлэх -16.11

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2-т заасны дагуу гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сангийн эх үүсвэр нь эрүүгийн торгох ялыг биелүүлсний 60 хувь, төрөөс олгосон нөхөн төлбөрийг гэм буруутай төлбөр төлөгчөөс нөхөн төлүүлсэн мөнгөн хөрөнгөөс бүрдэж байна. Уг санд 2012 оноос хойш нийт 31.4 тэрбум төгрөгийг төвлөрүүлжээ. Үүнд:

д/д	он	Мөнгөн дүн /өссөн дүнгээр/	Мөнгөн торгуулийн орлогоос	Буцаан төвлөрүүлэлт
1	2012 он	26.463.016	29.345.416	
2	2013 он	427.467.533	469.314.234	
3	2014 он	782.103.025	599.836.781	
4	2015 он	740.785.025	135.228.483	
5	2016 он	688.045.695	181.999.486	
6	2017 он	1.167.430.618	573.902.682	78.558.114
7	2018 он	3.729.853.354	2.620.280.973	102.756.688
8	2019 он	7.065.118.136	3.403.201.150	155.968.714
9	2020 он	10.675.109.645	3.893.420.508	128.351.753
10	2021 он	13.724.271.179	3.178.224.732	218.668.421
11	2022 он	17.453.630.797	4.016.783.978	205.857.956
12	2023 он	24.820.631.863	7.282.053.286	84.947.780
13	2024 он 11 сар	31.454.364.869		100.015.789

Дээрх хууль болон журмын дагуу Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2012 оноос 2024 онд нийт 30 удаагийн тушаалаар 516 хохирогч иргэнд 3.2 тэрбум төгрөгийн нөхөн төлбөрийг "Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сан"-аас олгоод байна. Үүнд:

/төгрөг/

№	ХЗДХСайдын тушаал		Сангаас олгосон		Дуусгавар болсон г/х	Санд төвлөрүүлсэн	Санд буцаан төвлөрүүлэх үлдэгдэл
	Огноо	дугаар	Төлбөр авагчийн тоо	Хохирлын мөнгөн дүн			
1	2012.11.02	А/59	1	2.882.500	1	2.882.500	-

2	2013.05.03	A/96	7	18.748.370	5	12.148.520	6.599.850
3	2013.09.04	A/188	8	29.852.444	8	29.852.444	-
4	2013.12.09	A/253	9	19.708.903	6	12.855.642	6.853.261
5	2014.03.13	A/18	14	49.195.813	12	39.237.887	9.957.926
6	2014.12.23	A/240	47	196.005.476	35	113.586.021	82.419.445
7	2015.03.24	A/67	14	45.984.810	11	40.576.865	5.407.945
8	2015.07.03	A/146	21	68.220.655	16	56.784.197	11.436.458
9	2015.11.24	A/264	17	62.341.018	9	38.737.613	23.603.405
10	2016.04.08	A/103	16	51.275.822	12	40.445.296	10.830.526
11	2016.08.23	A/23	23	103.112.966	15	70.027.553	33.085.413
12	2016.12.12	A/113	21	80.350.028	16	57.735.591	22.614.437
13	2017.04.18	A/91	18	76.491.984	9	50.663.748	25.828.237
14	2017.11.30	A/281	21	96.583.889	14	69.698.565	26.885.324
15	2018.04.27	A/81	16	87.510.740	13	68.635.736	18.875.004
16	2018.05.25	A/102	3	19.314.620	1	7.979.727	11.334.893
17	2018.10.04	A/189	12	53.789.565	7	29.136.672	24.652.893
18	2019.09.06	A/173	18	97.222.571	8	59.853.248	37.369.323
19	2019.12.09	A/228	19	126.682.511	7	63.643.688	63.038.823
20	2020.06.02	A/94	33	411.780.752	16	103.261.545	308.519.208
21	2021.04.19	A/85	45	261.688.174	16	68.171.379	193.516.795
22	2021.09.30	A/214	9	76.539.362	4	43.241.469	33.297.893
23	2021.12.20	A/292	2	9.504.083	-	47.911	9.456.172
24	2022.02.21	A/29	4	29.755.320	-	3.512.700	26.242.620
25	2022.06.22	A/168	49	375.093.132		101.706.023	273.387.109
26	2022.11.11	A/311	8	88.433.865		12.206.982	76.231.883
27	2023.03.28	A/144	13	110.876.588.83	2	22.338.464	88.538.125
28	2023.11.30	A/406	23	218.487.433		16.966.853	201.520.590
29	2024.04.09	A/101	12	157.200.082		710.036	156.490.046
30	2024.07.24	A/02	13	226.831.507	1	31.061.912	195.769.595
Нийт дүн			**516**	**3.251.469.994**	**244**	**1.267.706.787**	**1.983.763.199**

Санд 2012 оноос 2017 онд 78.558.114 төгрөг, 2018 онд 102.756.688 төгрөг, 2019 онд 155.968.714 төгрөг, 2020 онд 128.351.753 төгрөг, 2021 онд 218.668.421 төгрөг, 2022 онд 205.857.957 төгрөг, 2023 оны 134.714.606 төгрөг, 2024 оны 11 дүгээр сарын байдлаар 100.015.789 төгрөг, нийт 1.267.706.787 төгрөгийг буцаан төвлөрүүлсэн.

Сангаас олгосон төлбөр төлөгч нарын 73.88 хувь нь Эрүүгийн хуулийн Тусгай ангийн 10.1 /91.1/-т заасан хүн алах, 16.86 хувь нь Эрүүгийн хуулийн Тусгай ангийн 11.1 /96.1, 96.2/ буюу хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах, 0.41 хувь нь Эрүүгийн хуулийн Тусгай ангийн 11.4-т заасан хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах, 8.85 хувь нь Эрүүгийн хуулийн Тусгай ангийн 12.1 /126.1/-т заасан хүчиндэх гэм хэргийн улмаас учирсан хохирол төлбөрт олгосон байна.

Эмчилгээний зардалд 88 иргэнд 675.964.790 төгрөг, оршуулгын зардалд 426 иргэний 2.570.377.173 төгрөг, хөдөлмөрийн чадвараа алдсан 2 иргэний 5.123.031 төгрөгийг тус тус олгосон.